



82

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2010 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 598

Улаанбаатар хот

Г Сургалтын төрийн сангийн
зээлээр гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын хуралдааны шийдвэр, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Америкийн Нэгдсэн Улсын Фулбрайтын сан, Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын боловсролын институттэй тус тус байгуулсан гэрээ, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хавсралтад дурьдсан 10 хүнийг Сургалтын төрийн сангийн зээлээр Америкийн Нэгдсэн Улсын их, дээд сургуульд 2 жилийн хугацаатайгаар суралцуулсугай.


2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох байгууллагын нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /С.Наранцогт/, Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/ -д тус тус даалгасугай.

САЙД



Д.ОТГОНБАЯР

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын
2010 оны 11 дугаар сарын 16-ны өдрийн 51 дугаар
тушаалын хавсралт



Америкийн Нэгдсэн Улсад
магистрантурын сургалтад хамрагдах суралцагчид

№	Овог, нэр	Мэргэжил
1	Зориг Туяа	Орон нутаг/Хот төлөвлөлт
2	Баясал Батдэлгэр	Мэдээлэл технологийн менежмент
3	Гантэмэр Золжаргал	Нийгмийн ажилтан
4	Цэвээндорж Солонго	Англи хэлний багш
5	Энхболд Жаргал	Нийгмийн ажилтан
6	Тэрэлж Батболд	Байгаль хамгаалал
7	Далайхүү Өнөржаргал	Тээврийн удирдлага ба худалдааны менежмент
8	Хүрэл Нинж-Эрдэнэ	Боловсрол
9	Ганболд Анаар	Нийгмийн эрүүл ахуй
10	Энхтөр Ариунаа	Боловсролын удирдлага